



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Д.Нарануяа Утас: 325093 Цахим хаяг: narantuyad@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14-15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	16-23
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	23-27
3.6 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	27-29
4. Аудитын тайлан	30
4.1 Ерөнхий зүйл.....	30
4.2 Материаллаг байдал.....	30
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	30-31
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	31-32
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	32
5. Аудитын илрүүлэлт	33-38
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	39-40

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БХД	Багахангай дүүрэг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
ХААА	Худалдан авах ажиллагааны төв
ДАА	Дотоод аудитын алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот төсөвт үйлдвэрийн газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СӨХ	Сууц өмчлөгчийн холбоо
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.05.25 № 71
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА,
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ А.СҮХБОЛД
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3 заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Дүүргийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

002023030

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дүүргийн Засаг дарга 2023 онд Нийслэлийн Засаг даргатай хийсэн гэрээгээр төлөөлөн хэрэгжүүлэх эрх, үүргийн хүрээнд 45 арга хэмжээг төлөвлөн ажиллаж биелэлт 95 хувь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 6 арга хэмжээний биелэлт 95.1 хувь, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 3 арга хэмжээний биелэлт 96.7 хувь, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 85 арга хэмжээг 88.5 хувь, нийт 194 арга хэмжээг 93.8 хувьтай биелүүлсэн байна.

Хамрагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,422,174.80	2,462,730.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	751,018.00	1,315,191.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	55,454.30	40,097.90
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	14,919.10	2,606.40
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	600,783.40	817,245.60
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0	287,588.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		13,700,621.60	14,606,953.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	13,700,621.60	14,606,953.00
39200	Биет хөрөнгө		13,460,795.80	14,153,789.70
39300	Биет бус хөрөнгө	13	239,825.80	453,163.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		15,122,796.30	17,069,683.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		56,091.40	121,380.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	56,091.40	121,380.20
41300	Өглөг	17а, 17б	55,772.10	118,396.00
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	319.3	2,984.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		15,066,704.90	16,948,302.90
51	Засгийн газрын хувь оролцоо		15,066,704.90	16,948,302.90
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,115,911.00	2,115,911.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		6,441,015.00	3,095,543.40
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		162,060.10	356,188.90
51200	Хуримтлагдсан үр дүн		2,848,254.60	7,783,852.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,499,464.20	3,596,807.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		15,122,796.30	17,069,683.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		8,561,061.00	10,340,643.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		995,177.30	1,413,714.20
110	Орлогын албан татвар		879,786.50	1,205,746.00
1100	Хувь хүний орлогын албан татвар		879,786.50	1,205,746.00
113	Хөрөнгийн албан татвар		34,967.40	59,716.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		80,423.40	148,251.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,614,786.20	3,450,461.80
120	Нийтлэг татварын бус орлого		3,371,436.40	3,073,544.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		243,349.90	376,917.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,951,097.40	5,476,467.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	7,142,803.80	9,049,332.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,142,803.80	9,049,332.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,513,193.60	6,883,877.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,627,521.40	2,303,316.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		202,521.60	281,351.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		431,931.30	434,537.70
2104	Хангамж, бараа материалын зардал		104,490.90	109,657.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		48,053.80	47,761.30
2107	Томилолт, зочны зардал		19,452.00	33,938.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,155,765.10	1,143,543.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,923,457.60	2,529,770.80
212	ТАТААС		1,543,189.40	2,058,819.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		86,420.80	106,635.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,418,257.20	1,291,310.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		5,380,457.60	137,011.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-3,962,200.40	1,154,299.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		7,927,829.30	8,741,954.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		995,177.30	1,413,714.20
110	Орлогын албан татвар		879,786.50	1,205,746.00
1100	Хувь хүний орлогын албан татвар		879,786.50	1,205,746.00
113	Хөрөнгийн албан татвар		34,967.40	59,716.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж		80,423.40	148,251.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		25,669.60	38,135.40
1181	Газрын төлбөр		52,207.90	103,779.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		2,546.00	6,336.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,967,422.40	1,851,773.50
120	Нийтлэг татварын бус орлого		2,724,072.60	1,474,855.80
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		243,349.90	376,917.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,965,229.50	5,476,467.10
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,787,196.70	7,746,424.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,787,196.70	7,746,424.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,906,983.10	7,290,989.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,686,694.70	3,528,772.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		503,058.50	628,009.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		685,647.20	733,020.60
2104	Хангамж, бараа материалын зардал		877,310.30	996,228.40
2105	Нормативт зардал		4,496.00	350
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		62,859.70	60,378.10
2107	Томилолт, зочны зардал		31,452.00	21,938.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		799,870.90	752,539.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		255,593.80	569,752.10

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

212	ТАТААС		1,543,189.40	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		337,024.20	455,434.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		140,632.60	995,530.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		470,671.80	431,356.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		470,671.80	431,356.80
2200	Дотоод эх үүсвэрээр		470,671.80	431,356.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-470,671.80	-431,356.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-330,039.20	564,173.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,081,057.20	751,018.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		751,018.00	1,315,191.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,244,934.55	5,571,578.55	2,746,333.67	17,562,846.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,998,731.82	-2,109,913.20	4,064,121.31	-44,523.71
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,246,202.73	3,461,665.36	6,810,454.98	17,518,323.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	37,798.87	00.00	37,798.87
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Өмчид гарсан өөрчлөлт	1,472,783.36	0	0	1,472,783.36
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,962,200.41	-3,962,200.41
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,718,986.09	3,499,464.23	2,848,254.57	15,066,704.89

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,718,986.09	3,499,464.23	2,848,254.57	15,066,704.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	194,128.80	152,788.13	3,781,298.23	4,128,215.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,913,114.89	3,652,252.36	6,629,552.80	19,194,920.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-55,444.89	00.00	-55,444.89
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Өмчид гарсан өөрчлөлт	-3,345,471.57	00.00	00.00	-3,345,471.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,154,299.35	1,154,299.35
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,567,643.32	3,596,807.47	7,783,852.14	16,948,302.93

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,204,964,900.00	6,682,745,120.66	522,219,779.34	92.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,896,464,900.00	6,391,883,216.66	504,581,683.34	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,300,367,000.00	3,877,628,891.66	422,738,108.34	90.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,648,839,500.00	2,302,999,030.02	345,840,469.98	86.9
210101	Үндсэн цалин	1,569,474,300.00	1,403,787,124.93	165,687,175.07	89.4
210102	Нэмэгдэл	516,577,700.00	360,005,778.81	156,571,921.19	69.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	271,850,600.00	219,588,151.82	52,262,448.18	80.8
210104	Урамшуулал	218,297,100.00	246,978,238.48	-28,681,138.48	113.1
210105	Гэрээт ажлын хөлс	72,639,800.00	72,639,735.98	64.02	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	318,773,600.00	277,978,125.16	40,795,474.84	87.2
210201	Тэтгэврийн даатгал	216,506,700.00	196,006,132.91	20,500,567.09	90.5
210202	Тэтгэмжийн даатгал	25,501,500.00	21,180,547.32	4,320,952.68	83.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,561,900.00	16,601,962.56	3,959,937.44	80.7
210204	Ажилгүйдлийн даатгал	5,117,400.00	3,865,940.84	1,251,459.16	75.5
210205	Эрүүл мэндийн даатгал	51,086,100.00	40,323,541.53	10,762,558.47	78.9

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	462,117,100.00	434,799,578.16	27,317,521.84	94.1
210301	Гэрэл, цахилгаан	50,456,900.00	44,927,987.43	5,528,912.57	89.0
210302	Түлш, халаалт	363,141,800.00	352,189,210.00	10,952,590.00	97.0
210303	Цэвэр, бохир ус	45,818,400.00	34,982,380.73	10,836,019.27	76.4
210304	Байрны түрээс	2,700,000.00	2,700,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	96,175,500.00	92,038,275.32	4,137,224.68	95.7
210401	Бичиг хэрэг	27,371,600.00	26,624,345.00	747,255.00	97.3
210402	Тээвэр, шатахуун	22,050,000.00	21,713,526.00	336,474.00	98.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,821,800.00	13,424,096.32	2,397,703.68	84.8
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,116,900.00	2,617,628.00	499,272.00	84.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,315,200.00	27,158,680.00	156,520.00	99.4
2105	Нормативт зардал	350,000.00	350,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	350,000.00	350,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,301,400.00	94,035,680.00	265,720.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,390,000.00	35,383,880.00	6,120.00	100.0
210604	Урсгал засвар	58,911,400.00	58,651,800.00	259,600.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	22,306,000.00	21,938,800.00	367,200.00	98.4
210702	Дотоод албан томилолт	22,306,000.00	21,938,800.00	367,200.00	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	361,578,100.00	360,409,479.00	1,168,621.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	353,042,100.00	352,703,910.00	338,190.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,385,000.00	1,024,410.00	360,590.00	74.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	566,800.00	526,752.00	40,048.00	92.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	432,000.00	209,000.00	223,000.00	48.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,474,700.00	2,385,500.00	89,200.00	96.4
210807	Газрын төлбөр	677,500.00	589,907.00	87,593.00	87.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	470,000.00	30,000.00	94.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,925,800.00	293,079,924.00	2,845,876.00	99.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	282,275,900.00	281,412,924.00	862,976.00	99.7

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,649,900.00	11,667,000.00	1,982,900.00	85.5
212	ТАТААС	2,061,713,800.00	2,058,819,540.00	2,894,260.00	99.9
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,061,713,800.00	2,058,819,540.00	2,894,260.00	99.9
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,061,713,800.00	2,058,819,540.00	2,894,260.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	534,384,100.00	455,434,785.00	78,949,315.00	85.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	426,720,900.00	382,663,805.00	44,057,095.00	89.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	426,720,900.00	382,663,805.00	44,057,095.00	89.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,663,200.00	72,770,980.00	34,892,220.00	67.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,300,000.00	4,300,000.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,100,000.00	2,097,000.00	3,000.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,613,200.00	30,356,880.00	34,256,320.00	47.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,650,000.00	36,017,100.00	632,900.00	98.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	308,500,000.00	290,861,904.00	17,638,096.00	94.3
221001	Их засвар	5,000,000.00	4,750,000.00	250,000.00	95.0
223001	Бусад хөрөнгө	303,500,000.00	286,111,904.00	17,388,096.00	94.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,204,964,900.00	6,721,249,025.66	483,715,874.34	93.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	382,720,900.00	376,917,710.00	5,803,190.00	98.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	382,720,900.00	376,917,710.00	5,803,190.00	98.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,319,099,900.00	6,326,788,007.66	-7,688,107.66	100.1
320001	Орон нутгийн төсвөөс	6,319,099,900.00	6,326,788,007.66	-7,688,107.66	100.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	503,144,100.00	17,543,308.00	485,600,792.00	3.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,300,000.00	17,543,308.00	1,756,692.00	90.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	483,844,100.00	0	483,844,100.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	21,850,062.00	-21,850,062.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	60,353,967.00	-60,353,967.00	

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	246	218	28	88.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120	106	14	88.3
620001	Удирдах ажилтан	20	20	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	62	55	7	88.7
620003	Үйлчлэх ажилтан	30	23	7	76.7
620004	Гэрээт ажилтан	8	8	0	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	423,728,684.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,728,684.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,309,294.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,963,075.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,963,075.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	298,346,219.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	298,346,219.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,419,390.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,419,390.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	11,419,390.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	423,728,684.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	423,728,684.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,190,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,156,219.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,382,465.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тус дүүрэг нь зорилгоо “Төрийн захиргаа, иргэн, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн, үнэн зөв, ил тод мэдээллийн эх сурвалж ашиглан, дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчилдэг, өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин

нөхцөлийг бүрдүүлж, дүүргийн удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тодорхойлсон зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

- УИХ, Засгийн газрын хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж хяналт тавих;
- Дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд төсвийн хөрөнгийн урсгалыг чиглүүлэх;
- Дүүргийн төсвийн орлогын боломжит бүх эх үүсвэрийг дайчлах, татвар ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, татвар хураалтыг эрчимжүүлэх;
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт зарцуулалтад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг сайжруулах, дүүргийн хөгжлийн бодлого болон төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангаж, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд тэвчиж болох зардлыг хэмнэх, бууруулах, орон тоог нэмэгдүүлэхгүй байхад анхаарч, төлөвлөхдөө төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн нэмэгдүүлэх мөрдөж байгаа төсвийн норм үнэлгээ, үйлчилгээний үнэ тарифыг үндэслэн тэвчиж боох зардлуудыг багасгах, сул давхардсан орон тоог хасах зэргээр урсгал зардлыг хэмнэх бууруулах;
- Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;
- Засаг даргын бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглүүлж, холбогдох байгууллагуудтай нягт уялдаатай хамтран ажиллах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус дүүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, заавар журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 тогтоолоор төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан

- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан.
- Засгийн газрын 2023 оны 242 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-д өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам" баталж 9 дүгээр сараас мөрдсөн ба Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.
- Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 101.2 заалтад өөрчлөлт орсон.
- Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор Төрийн болон албаны нууцын тухай өөрчлөлт оруулсан.
- Засгийн газрын 2023 оны 243 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-д өөрчлөлт орсон.
- ЗГ-н 2023 оны 02-р сарын 08-ны өдрийн 49 тогтоолоор 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласан.
- ЗГ-ын 203 дугаар тогтоолоор "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам" тогтоолууд шинэчлэн батлагдсан байна.

Дүүргийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагаар ханган төсвийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 онд 14 байгууллагад шилэн дансны хуулийн хэрэгжилт, 5 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аудитаар 14 зөрчил илрүүлж зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 94.2 хувьтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Багахангай дүүрэг нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Тус дүүргийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,946,886.8 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	751,018.00	1,315,191.80	564,173.80
Авлага	55,454.20	40,097.90	(15,356.30)
Урьдчилгаа	14,919.10	2,606.40	(12,312.70)
Бараа материал	600,783.40	817,245.60	216,462.20
Нөөцийн бараа	-	287,588.40	287,588.40
Үндсэн хөрөнгө	13,700,621.60	14,606,953.00	906,331.40
Нийт хөрөнгө	15,122,796.30	17,069,683.10	1,946,886.80
Өр төлбөр	56,091.40	121,380.20	65,288.80

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,066,704.90	16,948,302.90	1,881,598.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,122,796.30	17,069,683.10	1,946,886.80

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Мөнгөн хөрөнгө өссөн нь татварын орлого төлөвлөгөөнөөс 512,460.1 мянган төгрөгөөр давж биелсэн, орон нутгийн төсвийн байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Авлага данс буурсан нь Илч-орд ОНӨҮГ-ын дулаан, халаалтын авлага барагдуулалт их байсан нь нөлөөлсөн.

Бараа материал өссөн нь Дүүргийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хийгдэж байгаа дуусаагүй ажлыг бараа материалд бүртгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар хийгдсэн болон хандив тусламжаар ирсэн 1,614,361.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өглөг өссөн нь дуусаагүй ажлын олгогдоогүй санхүүжилтийн өглөг, барьцааны өглөг нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь Илч Орд ОНӨААҮГазар нь өмнөх онд хандив тусламж, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,605,165.9 мянган төгрөгийн хөрөнгөөр Засгийн хувь оролцоог нэмэгдүүлж бүртгэснийг тайлан онд залруулсантай холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,315,191.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 564,173.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	358.50	358.50
Банканд байгаа бэлэн мөнгө	-	-	-
Төрийн сангийн харилцах	634,585.00	1,199,295.20	564,710.20
Арилжааны банк дахь харилцах	105,792.00	110,180.00	4,388.00
Арилжааны банк дахь харилцах			-
Замд яваа мөнгөн хөрөнгө	10,641.00	5,358.10	(5,282.90)
Дүн	751,018.00	1,315,191.80	564,173.80

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

2023 оны жилийн эцсийн байдлаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,315,191.8 мянган төгрөг байгаа нь арилжааны банканд 110,538.5 мянга, төрийн сангийн үлдэгдэл 1,199,295.1 мянга, замд яваа мөнгөн хөрөнгийн үлэгдэл 5,358.1 мянган төгрөг байна.

Байгууллагаар ангилбал :

ОНӨААТҮГ-уудын үлдэгдэл -110,538.5 мянган төгрөг (Илч-Орд ОНӨААТҮГ-41,837.0 мянга, Хот тохижилтын алба- 31,480.8 мянга, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж - 37,220.7 мянга), Орон нутгийн ерөнхий орлого дансанд 1,079,079.6 мянган төгрөг (үүнээс замд яваа 5,358.1 мянга), барьцаа дансны үлдэгдэл 61,356.7 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 60,354.0 мянган төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг мөнгөн хөрөнгийн журналаас түүвэрлэн шалгахад Нийслэлийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны А/79 захирамжаар эрх олгосны дагуу 20,000.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардал гаргаж төсвийн зориулалт бусаар зарцуулсан байна. (БХД-ийн ИТХ)
- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 32,781.0 мянган төгрөгийн" онцгой комисст автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх" төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь дүүргийн хөгжлийн бодлого зорилттой уялдаагүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол багатай, иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага хангаагүй, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна. (БХД-ийн Хөрөнгө оруулалт)

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 40,097.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,356.3 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	410.00	-	(410.00)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Дансны авлага /ТӨҮГ/	54,842.40	33,885.20	(20,957.20)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	14.90	14.90
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	201.90	6,197.80	5,995.90
Хувь хүмүүсээс авах авлага			-
Дүн	55,454.20	40,097.90	(15,356.30)

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

2023 онд авлага өмнөх буурсан нь Илч-орд ОНӨААТҮГ-ын дулаан, халаалтын

авлага барагдуулалт их байгаагаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдлийг байгууллагаар харуулбал: Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж 14.9 мянга, Илч-Орд ОНӨААТҮГ 33,716.3 мянга, ЗДТГ 3,733.0 мянга, ИТХ 112.8 мянга, Багахангай Хот тохижилт 168.9 мянга, ХААА 2.0 мянга, Орон нутгийн хөрөнгө оруулалт 2,350.0 мянга байна.

Аудитын илрүүлэлт:

- Түрээсийн орлогыг тулган шалгахад түрээслэгчээс авах авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлага 169.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, айл өрхийн халаалтын орлогоос үүссэн Хангай СӨХ-тэй холбоотой авлага 10-аас дээш жилийн насжилттай ба уг авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй. (БХД-ийн ЗДТГ, Багахангай Илч-орд ОНӨААТҮГ)

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2,606.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,312.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	14,919.10	2,606.40	(12,312.70)
Урьдчилгаа тооцоо	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Дүн	14,919.10	2,606.40	(12,312.70)

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан нь ИТХ-ийн өмнөх онд урьдчилж гарсан 12,000.0 мянган төгрөгийн сургалтын зардлыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 817,245.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 216,462.3 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	600,783.30	817,245.60	216,462.30
Бичиг хэргийн материал	14,802.90	22,213.80	7,410.90
Аж ахуйн материал	386,799.50	288,616.60	(98,182.90)
Сэлбэг хэрэгсэл	886.30	3,572.30	2,686.00
Түлш, шатах тослох материал		2,386.20	2,386.20

Бусад хангамжийн материал	198,294.60	500,456.70	302,162.10
Дүн	600,783.30	817,245.60	216,462.30

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Тайлант онд бараа материал худалдан авсан 1,167,553.0 мянга, хандиваар авсан 297,325.0 мянга, шилжүүлсэн авсан мянга, бусад 661,499.1 мянга нийт 2,126,377.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 991,280.4 мянга, бусад 631,046.0 мянга, нийт 1,622,326.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалыг түүвэрлэн шалгахад 23,389.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан ч үлдэгдлээр тайлагнасан. (Багахангай гэрэлтүүлэг,ногоон байгууламж ОНӨААТҮГ-22,973.7 мянга, Багахангай ЖДҮДТ- 415.3 мянга)

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 287,588.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 287,588.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад нөөц		287,588.40	287,588.40
Дүн	-	287,588.40	287,588.40

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөж байгаа 21 ажлын 287,588.4 мянган төгрөгийн зураг төсөв зөвлөх үйлчилгээг бараа материалын нөөц дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 14,606,953.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 906,331.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	13,460,795.80	14,153,789.70	692,993.90
Барилга, байгууламж, орон сууц	8,046,045.70	8,381,540.90	335,495.20
Авто-тээврийн хэрэгсэл	1,281,305.80	1,593,686.30	312,380.50
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,983,025.20	2,099,806.70	116,781.50

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тавилга, аж ахуйн эд хогшил	138,708.10	115,933.60	(22,774.50)
Бусад үндсэн хөрөнгө	1,989,958.50	1,935,915.40	(54,043.10)
Ном	21,752.50	23,906.80	2,154.30
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай		3,000.00	3,000.00
Биет бус хөрөнгө	239,825.80	453,163.30	213,337.50
Программ хангамж	10,839.40	22,324.90	11,485.50
Бусад биет бус хөрөнгө	228,986.40	430,838.40	201,852.00
Бусад хөрөнгө /ТӨҮГ/			-
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			-
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			-
Дүн	13,700,621.60	14,606,953.00	906,331.40

Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 906,331.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 57,446.8 мянган төгрөг, хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр 1,614,361.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр: ЗДТГ- 39,773.0 мянга, Соёлын төв ордон 6,500.0 мянга, ИТХ- 4,679.7 мянга, ХААА- 6,493.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авчээ.

Хөрөнгө оруулалт, хандив тусламжаар :

- ЗДТГ -1,584,511.8 мянган төгрөг (*гэрэлтүүлгийн шон удирдлагын самбар 165,510.7 мянган төгрөг, авто машины зогсоол 97,840.3 мянган төгрөг, авто зам засварын ажил 49,975.0 мянган төгрөг, худгийн засвар 5,000.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгөөр барилгын их засварын ажил 716,320.3 мянган төгрөг, нийслэлийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хүүхэд зөөх зориулалт бүхий автобус 307,333.3 мянган төгрөг, дүүргийн төсвийн хөрөнгөөр суудлын авто машин 32,781.0 мянган төгрөг, хурлын заалны тоног төхөөрөмж 19,756.00 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн орон сууцны гадна тохижилтын ажил, ахмадын хорооны гаднах хашаа хайс 114,535.6 мянган төгрөг, 1, 2-р хорооны ногоон байгууламжийн хашаа хайс 75,459.6 мянган төгрөг*)
- Соёлын төв ордон -82,085.9 мянган төгрөгийг (*нийслэлийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж 73,231.6 мянган төгрөг, газар 7,200.0 мянган төгрөгөөр, ном 1,654.3 мянган төгрөг*) холбогдох шийдвэр тушаалыг үндэслэн хөрөнгөнд тус тус бүртгэн авчээ.

Дотоод аудитын алба ашиглах хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой 12,485.1 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэр гаргуулж дахин үнэлсэн авсан.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд гарсан хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох шийдвэр, дэлгэрэнгүй бүртгэлээс түүвэрлэн шалгахад 6,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн, 2,300 мянган төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна. (*БХД-ийн ЗДТГ*)

- Үндсэн хөрөнгийг түүвэрлэн шалгахад 15,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл ашиглалтгүй байна. (Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ)

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 121,380.2 төгрөг болж, өмнөх оноос 65,288.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	14.30	4,412.20	4,397.90
Байгууллагад төлөх өглөг	27,792.80	85,119.40	57,326.60
Хувь хүмүүст өгөх өглөг		72.40	72.40
Дансны өглөг /ТӨҮГ	27,964.90	28,792.00	827.10
Урьдчилж орсон орлого	319.30	2,984.20	2,664.90
Дүн	56,091.30	121,380.20	65,288.90

Эх сурвалж: “Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”

Өглөг нэмэгдсэн нь ОНХС -ийн нэг дуусаагүй ажлын олгогдоогүй санхүүжилт болон тайлант онд нэмэгдсэн барьцааг өглөгөөр бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Татварын цахим төлбөрийн баримтын системд 2023 оны 5-р сарын санхүүжилтийн орлогыг 2 дахин бүртгэсэнтэй холбоотой татварын тодорхойлолтоор илэрхийлэгдсэн НӨАТ-ын өглөг нь байгууллагын бүртгэлд тусгасан НӨАТ-ын өглөгийн дүнгээс 23,995.4 мянган төгрөгөөр зөрүүтэй. (Багахангай Илч-орд ОНӨААТҮГ)

3.5.8 Урьдчилж орсон орлого

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 2,984.2 мянган төгрөг болж өмнөх оноос 2,664.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9 Урьдчилж орсон орлого

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	мянган төгрөгөөр
			Өсөлт (+), Бууралт (-)
Бусад урьдчилж орсон орлого	319.3	2,984.2	2,664.9
Дүн	319.3	2,984.2	2,664.9

Илч-Орд ХХК-аас 2,664.9 мянган төгрөгийн орлого нэмэгдсэн нь харилцагч байгууллагаас эм авч халаалтын төлбөрт тооцоо бууруулахтай холбоотой үүссэн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 16,948,300.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,881,596.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,115,911.00	2,115,911.00	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	6,441,015.00	3,095,543.40	(3,345,471.60)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	162,060.10	356,188.90	194,128.80
Хуримтлагдсан үр дүн	2,848,254.50	7,783,850.10	4,935,595.60
Өмнөх үеийн үр дүн	6,810,454.90	6,629,552.80	(180,902.10)
Тайлант үеийн үр дүн	(3,962,200.40)	1,154,297.30	5,116,497.70
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,499,464.20	3,596,807.50	97,343.30
Дүн	15,066,704.80	16,948,300.90	1,881,596.10

Эх сурвалж: "Багахангай дүүргийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь Илч Орд ОНӨААҮГазар нь өмнөх онд хандив тусламж, хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,605,165.9 мянган төгрөгийн хөрөнгөөр Засгийн хувь оролцоог нэмэгдүүлж бүртгэснийг тайлан онд залруулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улс, нийслэл, дүүргийн төсвөөс 7,006,426.5 мянга, үйл ажиллагааны орлогоос 8,900.0 мянга, нийт зарлагыг 7,015,326.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 872,811,6 мянган төгрөгөөр бууруулж, 6,142,514.9 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь 2023 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2. Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 67-ны А/39 дугаар тогтоолоор анх дүүргийн татварын болон татварын бус орлогыг 1,162,154.0 мянга, нийслэлийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 4,881,260.9 мянга, нийслэлийн ОНХС-аас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 301,010.7 мянга, төсвийн урьд оны үлдэгдлээс 82,000.0 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 17,100.0 мянга нийт 6,443,525.6 мянган төгрөгөөр, үүнээс төсвийн нийт зарлагыг 6,443,525.6 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан дүүргийн ИТХ-ын 2023 оны “Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” А/22 дугаар тогтоолоор дүүргийн татварын болон татварын бус орлогыг нийт 1,247,154.0 мянга, нийслэлийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 5,071,945.9 мянга, нийслэлийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 382,720.9 мянга, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 10,000.0 мянга, дүүргийн төсвийн урьд оны үлдэгдлээс 473,844.1 мянга, төсвийн байгууллагын өөрийн орлого 19,300.0 мянга, нийт 7,204,964.9 мянган төгрөгөөр, үүнээс төсвийн нийт зарлагыг 7,204,964.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 1,266,454.0 мянган төгрөгийн урсгал /татварын болон татварын бус/ орлогыг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 1,778,914.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 140.5 хувиар биелүүлжээ.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН/III+IV/	1,266,454.00	1,778,914.10	512,460.10	140.5
ТАТВАРЫН ОРЛОГО	1,037,154.00	1,413,714.10	376,560.10	136.3
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР	954,154.00	1,309,525.60	355,371.60	137.2
Хувь хүний албан татвар	954,154.00	1,309,525.60	355,371.60	137.2
Цалин хөлс болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	796,474.00	964,271.60	167,797.60	121.1
Иргэдийн хадгаламжийн хүүгийн татвар	32,000.00	26,283.60	-5,716.40	82.1
Үйл ажиллагааны орлогын албан татвар	30,000.00	176,088.60	146,088.60	587.0
Хөрөнгө борлуулсны орлого	36,000.00	39,102.00	3,102.00	108.6
Газрын төлбөр	59,680.00	103,779.70	44,099.70	173.9
Өмчийн татвар	46,000.00	59,716.60	13,716.60	129.8
Бууны албан татвар	1,000.00	690.00	-310.00	69.0
малд ногдуулах татвар	5,000.00	5,915.80	915.80	118.3
үл хөдлөх хөрөнгийн татвар	40,000.00	53,110.80	13,110.80	132.8
Бусад татвар	37,000.00	44,471.90	7,471.90	120.2

Улсын тэмдэгтийн хураамж	10,000.00	7,335.70	-2,664.30	73.4
Хог хаягдлын хураамж	25,000.00	30,799.70	5,799.70	123.2
Ус, ашигласны төлбөр	2,000.00	6,336.50	4,336.50	316.8
Татварын бус орлого	229,300.00	365,200.00	135,900.00	159.3
Хүү торгуулийн орлого	200,000.00	327,046.50	127,046.50	163.5
Ангилагдаагүй бусад орлого	10,000.00	20,610.20	10,610.20	206.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,300.00	17,543.30	-1,756.70	90.9

Төлөвлөгөө давж биелсэн орлогын төрлүүдийн хувьд:

- Хувь хүний орлогын албан татвар давсан нь татвар төлөгчдийн татварын тайлангаар банк бус санхүүгийн байгууллага ашигтай ажиллаж хувьцааны ногдол ашиг тараасантай холбоотой татвар төлсөн нь нөлөөлсөн байна.
- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого давж биелсэн нь цалин нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар давсан нь ногдлыг бүрэн барагдуулан ажилласантай холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлого давж биелсэн нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор иргэд үл хөдлөх хөрөнгөө борлуулах нь ихэссэнээс шалтгаалсан.
- Хог хаягдлын хураамж давсан нь дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төсөвт болон аж ахуй нэгж байгууллагууд хугацаандаа хураамжаа төлж барагдуулсантай холбоотой байна.
- Газрын төлбөр давж биелсэн нь өмнөх оны өртэй иргэдийн өрийг бүрэн барагдуулсан нь нөлөөлсөн.
- Малын тоо толгойн албан татвар давсан нь малын тоо өссөнөөс шалтгаалсан.
- Ус ашигласны төлбөр давж биелсэн нь 2023 онд шинээр 2 төмрийн үйлдвэр, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 2 газар тус тус хэрэглээний усны төлбөр төлөх болсонтой холбоотой байна.
- Хүү торгуулийн орлого давсан нь цагдаагийн байгууллагын торгууль нэмэгдсэнээс шалтгаалсан.

Төлөвлөгөө тасарч буй орлогын төрлүүдийн хувьд:

- Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого тасарсан нь иргэдийн банк дах мөнгөн хадгаламж буурсантай холбоотой байна.
- Бууны албан татвар буурсан нь уг төрөлд бүртгэлтэй 5 татвар төлөгч нас барсан бөгөөд галт зэвсэг нь хаана байгаа нь тодорхойгүйгээс төлөвлөгөө тасрах шалтгаан болсон байна.
- Улсын тэмдэгтийн хураамж буурсан нь тухайн онд улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт хийгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг 761,439.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

2023 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт улсын төсвөөс 382,720.9 мянга, нийслэлийн төсвөөс 5,071,945.9 мянга, орон нутгийн

төсвөөс 1,247,154.0 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих нь 483,844.1 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 19,300.0 мянга, нийт 7,204,964.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 376,917.7 мянга, нийслэл, орон нутгийн төсвөөс 6,326,788.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 17,543.3 мянга, нийт 6,721,249.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 6,682,745.1 мянган төгрөгийг зарцуулж 38,503.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 17,543.3 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1,756.7 мянган төгрөгөөр тасарсан нь ЖДҮДТ нь өөрийн орлого бүрдүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,682,745.1 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 345,840.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 40,795.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27,317.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 4,137.1 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 265.7 мянга, томилолт зочны зардлыг 367.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсний ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 1,168.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,845.2 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 78,949.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70105.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	717,548.60	712,229.40	5,319.20	99.3
2	70106.Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2,287,658.30	1,970,407.20	317,251.10	86.1
3	70418. Худалдан авах ажиллагаа	156,197.70	155,845.30	352.40	99.8
4	70429.Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	303,514.60	185,172.70	118,341.90	61.0
5	72101.ЖДҮ-ийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох	225,805.70	220,794.30	5,011.40	97.8
6	70901.Дулаан цахилгаан эрчим хүч	941,400.00	941,400.00	0.00	100.0
7	71502.Хот байгуулалт, тохижилт	719,622.40	716,728.10	2,894.30	99.6
8	71508.Гудамжны гэрэлтүүлэг	400,691.40	400,691.40	0.00	100.0
9	71702.Соёл урлаг	436,549.10	428,060.60	8,488.50	98.1
10	71802.Ерөнхий боловсрол	159,290.10	159,289.90	0.20	100.0
11	71801.Сургуулийн өмнөх боловсрол	93,359.80	90,649.30	2,710.50	97.1
12	70501. Орон нутгийн төсөвт олгох шилжүүлэг	397,720.90	353,413.80	44,307.10	88.9

13	70106. Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	303,500.00	286,111.90	17,388.10	94.3
14	71701.Биеийн тамир спорт	62,106.30	61,951.20	155.10	99.8
	Нийт дүн	7,204,964.90	6,682,745.10	522,219.80	92.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт эх үүсвэрээр ИТХ 112,000.0 мянга, ЗДТГ 309,728.7 мянга, Соёлын ордон 2,000.0 мянга, нийт 423,728.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч холбогдох шийдвэр журмын дагуу гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зардалд 111,963.0 мянга, соёлын арга хэмжээний зардалд 2,000.0 мянга, унааны нөхөн олговор, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, өвс тэжээл худалдан авах, бусад арга хэмжээний зардалд 298,346.3 мянга, нийт 412,309.3 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 11,419.4 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.5. ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын 2023 оны “Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” А/22 дугаар тогтоолоор 2023 онд хэрэгжих 11 төсөл, арга хэмжээнд 288,500.0 мянган төгрөгийн, 2022-2023 оны 2 төсөл, арга хэмжээнд 15,000.0 мянга, нийт 303,500.0 мянган төгрөгийн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр баталжээ.

Хөрөнгө оруулалтын 13 төсөл, арга хэмжээнд нийт 303,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд 261,843.2 мянга, техник хяналтын зардалд 1,659.5 мянга, барьцаа дансанд 19,929.8 мянга, зохиогчийн хяналтын зардалд 1,347.4 мянга, алданги 389.9 мянга, магадалшгүй ажлын зардал 941.9 мянга нийт 286,111.9 мянган төгрөгийг олгож, дүүргийн ерөнхий орлогын дансанд 17,388.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалт:

Нийслэлийн Багахангай дүүргийн ИТХ-ын 2023 оны “дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” А/22 дугаар тогтоолоор он дамжсан 1 төсөл, арга

хэмжээнд 18,980.0 мянга, 2023 онд хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний 378,740.9 мянга, нийт 397,720.9 мянган төгрөгийг 4 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр нийслэлийн ОНХС-ийн эхний үлдэгдэл 21,850.0 мянга, тайлант онд 391,917.7 мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэгч байгууллагад 331,336.4 мянга, барьцаа дансанд 19,809.0 мянга, техник хяналтын зардалд 1,512.3 мянга, зохиогчийн хяналтын зардалд 756.1 мянга, нийт 353,413.8 мянган төгрөгийг зарцуулж 60,353.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт барьцаа хөрөнгө: Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 50,124.9 мянган төгрөг байснаас 39,738.8 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 28,507.1 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж 33 төсөл, арга хэмжээний 61,356.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

3.6.6. ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Нийслэлийн Багахангай дүүргийн ОНӨААТҮГ-ууд нь 2023 онд нийт 2,918,929.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 3,402,235.4 мянган төгрөгийг зарцуулж, 483,305.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Орлого өмнөх оноос 774,241.1 мянган төгрөгөөр өссөн, зардал 626,426.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь нүүрсний үнэ өсч дүүргийн төв талбай засварлах, гэрэлтүүлэг, камерын засвар үйлчилгээ, өвлийн модны арчилгаа зэрэг ажилд нийслэл, дүүргийн төсвийн тодотголоор санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Дүүргийн ЗД-ын баталсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 2,614,736.9 мянган төгрөг буюу 13.9 хувь буюу 364,547.3 мянган төгрөгөөр давж биелүүлсэн, зардал 3,015,608.2 мянган төгрөг буюу 13.0 хувь буюу 394,013.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага хангасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, бараа материал, үндсэн хөрөнгийг үнэн зөв бүртгэж, тайлагнах, ашиглалтгүй болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, түрээсийн орлогод тавих хяналтыг сайжруулах, авлага

барагдуулах арга хэмжээ авч ажиллах, гэрээний хэрэгжилтийг хянах, ээлжийн амралтыг тушаал шийдвэрийг үндэслэн олгох, ажлаас чөлөөлөгдөх албан хаагчтай ээлжийн амралтыг тооцоог хийх, НБББББ-ийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн мөрдөх зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитор Д.Нарантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дарга дүүргийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/185 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 8,731,745.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 130,976.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус дүүрэг нь хангамж бараа материалын зардлаас 17,962.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсний ажил үйлчилгээний төлбөрөөс 9,708.3 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлаас 522,219.8 мянган төгрөгийн хэмнэлт бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд :

- Засаг даргын орлогчийн орон тоог нэгээр цөөлж, чөлөөтэй болон чөлөөлөгдсөн ажилтны орон тоонд шинээр томилгоо хийгээгүй, бүтэц орон тоог өмнөх оноос нэмэгдүүлээгүй зэргээс шалтгаалан цалингийн зардал хэмнэгдсэн байна.
- ЗДТГ нь 2 автомашиныг нийслэлийн Засаг даргын захирамж, НӨХГ-ын тушаалаар акталснаас өмнөх жилүүдэд төлөвлөгдөж байсан шатахууны зардлыг бууруулсан байна.
- Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулан тоолуур ашиглаж, барилгын гадна, доторх дулаалга, сантехникийн засвар хийснээр дулаан, цэвэр бохир усны алдагдал багасаж тогтмол зардалд хэмнэлт үүссэн байна.
- Албан бичиг хэрэг хөтлөлт цахимаар болон ERP системээр хийж байгаагаас бичгийн цаас, принтерийн хорны хэрэглээ багассан, төсвийн

байгууллагуудын албан тушаалтны гар утасны төлбөрийг төсөвт төсөвлөөгүй байна.

- Гадаад болон дотоодод албан томилолтоор явахдаа агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихгүй байх арга хэмжээ авч томилолтын зардлыг өмнөх оны түвшнээс нэмэгдүүлэхгүй байхад анхаарч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ажилтнуудад 12,112.5 мянган төгрөгийн урамшууллыг олгож төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. (БХД-ийн ЗДТГ-6,450.0 мянга, ДАА-5,662.5 мянга)

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

- Сургалт семинарын тоо өмнөх оноос өссөнөөс 2,581.3 мянган төгрөгөөр дотоод томилолтын зардал нэмэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:"15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" заалт зөрчсөн. (БХД-ийн ИТХ)
- УИХ-д суудалтай намд олгох төрийн санхүүгийн дэмжлэгийг дүүргийн иргэдийн төлөөлөгчдөд орон нутгийн төсвөөс 34,000.0 мянган төгрөгийг олгож намын дансанд шилжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;заалт, Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2."Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна." заалтыг зөрчсөн. (БХД-ийн ИТХ)
- Байгууллагад хэрэглэхийг хүлээн зөвшөөрсөн авто тээврийн хэрэгсэлд хуульд заасны дагуу цэнхэр улсын дугаар аваагүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, ЗГ-ын "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 204 дүгээр тогтоолын 6-р заалт, Стандарт, хэмжилзүйн газрын даргын баталсан "MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг болох Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалттай нийцэхгүй байна. (БХД-ийн ИТХ-1, ЗДТГ-8, Багахангай Илч-орд ОНӨААТҮГ-1)

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багахангай дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2023 онд нийт 14 төрлийн 6,721,120.8 мянган төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулахаас мэдээллийг бүрэн байршуулсан байна.

1.Санал дүгнэлт гаргасан 4 шалгагдагч байгууллага нь 2023 онд нийт 4,083,084.6 мянган төгрөгийн 320 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулахаас 75,803.5 мянган төгрөгийн орлого, зарлагын 9 гүйлгээг хугацаа хоцроож, 227,166.8 мянган төгрөгийн орлого, зарлагын 6 гүйлгээг дутуу мэдээлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 135,818.3 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 6,800.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг байршуулаагүй, 91,348.5 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 69,003.5 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.5 “*Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. /Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2.Аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн (*түүвэрт хамруулсан*) 5 шалгагдагч байгууллага нь 1,032,511.2 мянган төгрөгийн 169 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулахаас 25,551.1 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг байршуулаагүй байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25,551.4 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна. (БХД-ийн Соёлын ордон)

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын цахим төлбөрийн баримтын системд 2023 оны 5-р сарын санхүүжилтийн орлогыг 2 дахин бүртгэсэнтэй холбоотой татварын тодорхойлолтоор илэрхийлэгдсэн НӨАТ-ын өглөг нь байгууллагын бүртгэлд тусгасан НӨАТ-ын өглөгийн дүнгээс 23,995.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл 29.1.3. "Суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. (Багахангай дүүргийн Илч-Орд ОНӨААТҮГ)

Шийдвэрлэсэн нь: НӨАТ-ын тайланг хүсэлт илгээж засварлах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох зарим заалтыг хэрэгжүүлээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус дүүргийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 118,328.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 14 зөвлөмж өгч биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад зөрчил дахин давтагдаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 97,878.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн актыг барагдуулж, 1,014,919.1 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 215,121.0 мянган төгрөгийн 8 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	97,878.1	4	97,878.1	100
Албан шаардлага	8	1,014,919.1	8	1,014,919.1	100
Зөвлөмж	8	215,121.0	8	215,121.0	100

Нийт дүн	20	1,327,918.2	20	1,327,918.2	100
----------	----	-------------	----	-------------	-----

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нягтлан бодогч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн чадавхжуулах зардал, цахим мэдээлэл, санхүүгийн программ хангамжийн ашиглалт зэрэг асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 4 сан зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 6 байгууллага (ИТХ, ЗДТГ, ЖДҮДТ, ХААА, ДАА, Соёлын ордон), 4 сан, зардал (ОНХС, Хөрөнгө оруулалтын барьцаа, дүүргийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сан), аж ахуйн тооцоотой 3 байгууллага (Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ,-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2		8	
2	ОНӨААН		2	1	
	Дүн	2	2	9	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Өөрчлөлтгүй 4 (БХД-ийн ИТХ, ЗДТГ, “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ, “Багахангай Илч-Орд” ОНӨААТҮГ) санал дүгнэлт өглөө.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 2,187,719.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрсэнд аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд авлагыг 250.0 мянган төгрөгөөр илүү, өр төлбөрийг 2.0 мянган төгрөгөөр, эргэлтийн бус хөрөнгийг 7,200.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан. (БХД-ийн ЗДТГ-250.0 мянга, БХД-ийн ХААА-2.0 мянга, Соёлын ордон-7,200.0 мянга)
- Санхүүгийн байдлын тайланд 287,588.3 мянган төгрөгийн бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэсэн. (БХД-ийн ЗДТГ-287,588.3 мянга)
- Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлыг 12,513.4 мянган төгрөгөөр илүү, 19,751.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. (БХД-ийн ЗДТГ-11,013.4 мянга, ЖДҮДТ-1,500.0 мянга, БХД-ийн ЗДТГ-11,263.4 мянга, Соёлын ордон-8,488.5 мянга)
- Санхүүгийн үр дүнгийн тайланд эхний үлдэгдлийг 1,070,905.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. (БХД-ийн ИТХ-434,803.5 мянга, ЖДҮДТ-636,101.5 мянга)
- Мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг 511,439.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. (БХД-ийн ИТХ-429,201.8 мянга, ЖДҮДТ-82,237.5 мянга)
- Өмчийн өөрчлөлтийн тайланд эхний үлдэгдлийг 4,616.8 мянган төгрөгөөр, өмнөх үеийн үр дүнг 144,395.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. (БХД-ийн ИТХ-83,227.8 мянга, ДАА-4,616.8 мянга, ХААА-490.4 мянга, Илч-Орд ОНӨААТҮГ-60,677.5 мянга)
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг 556.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. (БХД-ийн ЗДТГ-556.1 мянга)
- Орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалтын орлогыг 1,051.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. (Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-1,051.5 мянга)
- Мөнгөн гүйлгээний тайланд 1,837.2 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй бүртгэсэн. (Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-877.5 мянга, Илч-Орд ОНӨААТҮГ-959.7 мянга)
- Бараа материалын дансыг ангилж бүртгээгүй 67,106.4 мянга, 3,450.0 мянган төгрөгийн материалын тоо хэмжээг зөрүүтэй бүртгэсэн. (Багахангай Тохжилт ОНӨААТҮГ-67,106.4 мянга, БХД-ийн ДАА-3,450.0 мянга)
- Тушаал, ажил дүгнэсэн ажлын хэсгийн шийдвэргүйгээр 22,022.3 мянган төгрөгийн илүү цаг, ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгосон. (Багахангай Тохжилт ОНӨААТҮГ-22,022.3 мянга)
- Нохой муур устгах ажлын гэрээ төсөв, гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй мөн бетон шал өнгөлөгч төхөөрөмж 2, зуурагч төхөөрөмж 2-ийг нийлүүлэх 14,492.8 мянган төгрөгийн гэрээ хийсэн боловч гэрээ хүчин төгөлдөр бус, ажлын тайлан байхгүй. (Багахангай Тохжилт ОНӨААТҮГ-14,492.8 мянга)
- Хог пресслэгч машин 16,000.0 мянган төгрөгөөр худалдан авалтад харьцуулсан үнийн судалгааг хавсаргаагүй. (Багахангай Тохжилт ОНӨААТҮГ-16,000.0 мянга)

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацааг санхүүгийн программд алдаатай оруулсантай холбоотой элэгдлийг зардлыг 2,375.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон. (*Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-2,375.0 мянга*)
- Даатгалын зардлыг мөнгөн сууриар бүртгэж 166.2 мянган төгрөгийн урьдчилж төлсөн даатгалын зардлыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй (*Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-166,2 мянга*) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Санхүүгийн тайлагналын Онолын үзэл баримтлал 7.7 болон 7.8 заалт, НББОУС-16 Үндсэн хөрөнгө 50 болон 55-р праграф НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 иж бүрэн байх, ангилал, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 104,354.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,405.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 102,949.9 мянган төгрөгийн 13 зөвлөмж өгсөн.

5.1.1 Орон нутгийн байгууллага

Аудитаар нийт 62,775.8 мянган төгрөгийн зөрчил³ илэрсэнд 8 зөвлөмж өгсөн.

5.1.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд

Аудитаар нийт 41,579.1 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 1,405.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 40,174.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

1. Байгууллагын дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр илүү цагийн хөлс 1,405.0 мянган төгрөг авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”; гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн

Аудитаар нийт 2,208.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд элэгдлийн зардлыг 2,208.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1.7.2 иж бүрэн байх, эрх ба үүрэг, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. (ТТЗ)

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1.Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 32,781.0 мянган төгрөгийн "онцгой комисст автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх" төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29-1.1."Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна."29-1.2.5."тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх".29-1.2.6."олон нийтээр хэлэлцүүлсэн байх" заалттай нийцэхгүй байна. (БХД-ийн Хөрөнгө оруулалт)

Өгсөн зөвлөмж: Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн хөгжлийн бодлого зорилттой уялдсан, эдийн засгийн үр ашиг нийгмийн ач холбогдолтой, иргэдээс санал авч эрэмбэлэгдсэн, төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага хангасан ажлыг санхүүжүүлэх;

5.2.2 Бараа материалын данстай холбоотой асуудал:

1 Илрүүлэлт: Бараа материалыг түүвэрлэн шалгахад 23,389.0 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадаагүй үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20-р зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна. (БХД-ийн ЖДҮДТ-415.3 мянга, Багахангай гэрэлтүүлэг,ногоон байгууламж ОНӨААТҮГ-22,973.7 мянга)

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг үнэн зөв тайлагнах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

5.2.3 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

1. Илрүүлэлт: Тайлант онд 6,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн, 2,300 мянган төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн зарим хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй байгаа нь хөрөнгө буруу бүртгэгдэх үр дагаврыг бий болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ",20.2.9."аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага

болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; удирдах,” 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтыг тус тус зөрчиж, толилуулга, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна (БХД-ийн ЗДТГ-8,300.0 мянга- 2/, Багахангай гэрэлтүүлэг,ногоон байгууламж ОНӨААТҮГ-15,900.0 мянга, Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ)

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зөв ангилан бүртгэх, ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг НӨХГ-т уламжлан шийдвэрлүүлэх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.2.4 Авлага,өглөгийн данстай холбоотой асуудал:

1.Илрүүлэлт: Түрээсийн орлогыг тулган шалгахад түрээслэгчээс авах авлагыг 169.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, 1,300.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж акт үйлдэж баталгаажуулаагүй, нь ажил гүйлгээ бүртгэлээс зөрүүтэй илэрхийлэгдэх үр дагаврыг бий болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтуудыг зөрчиж, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.(БХД-ийн ЗДТГ-169.4 мянга, Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ-1,300.4 мянга)

Өгсөн зөвлөмж:Түрээсийн тооцоог тухай бүр нийлж баталгаажуулах, орлогод тавих хяналтыг сайжруулах, авлагын насжилтын судалгааг гаргаж, авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах, хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянах дотоод хяналтыг сайжруулах;

5.2.5 Зардлын данстай холбоотой асуудал:

1.Илрүүлэлт:Цалин хөлс, нэмэгдэл, ээлжийн амралтын тооцооллыг давтан гүйцэтгэхэд амралтын цалинг 575.0 мянган төгрөгөөр илүү, 535.1 мянган төгрөгөөр дутуу тооцсон нь төсвийг хяналтгүй зарцуулах үр дагаврыг бий болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалт, заалтуудыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. (БХД-ийн ЗДТГ-2 буюу 1110.1 мянга)

Өгсөн зөвлөмж: Ээлжийн амралтыг тушаал шийдвэрийг үндэслэн олгох, ажлаас чөлөөлөгдөх албан хаагчтай ээлжийн амралтыг тооцоог хийж хэвших,

2.Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Нийслэлийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны А/79 захирамжаар эрх олгосны дагуу 20,000.0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын ажилд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7.”Гэмт хэрэг, зөрчлөөс

урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.”заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. (БХД-ийн ИТХ 20,000.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх, зардалд тавих хяналтыг сайжруулах;

5.2.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 оноос хойш шинэчлэн боловсруулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн байгуулах хугацаа буруу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна. (Багахангай Тохжилт ОНӨААТҮГ)

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан ахлах нягтлан бодогч шинэчлэн боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
БХД-ийн Засаг дарга	1	2,208.7			1	2,208.70	1	2,208.7		
БХД-ийн ИТХ	3	947,233.1	2	864,005.3	1	83,227.8	3	947,233.1		
БХД-ийн ЗДТГ	5	310,671.2	2	11,819.5	3	298,851.7	5	310,671.2		
БХД-ийн ДАА	2	8,066.8			2	8,066.8	2	8,066.8		
БХД-ийн ХАА	2	492.4	1	2.0	1	490.4	2	492.4		
БХД-ийн ЖДҮДТ	3	719,839.0	2	718,339.0	1	1,500.0	3	719,839.0		
БХД-ийн Соёлын ордон	2	15,688.5	1	7,200.0	1	8,488.5	2	15,688.5		
БХД-ийн Хөрөнгө оруулалт							0	-		
БХД-ийн ОНХС							0	-		
Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ	2	1,929.0			2	1,929.0	2	1,929.0		
Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ	5	64,178.4	2	2,541.2	3	61,637.2	5	64,178.4		
Багахангай Төхижилт ОНӨААТҮГ	4	119,621.5			4	119,621.5	4	119,621.5		
Байгаль хамгаалах сан							0	-		
Дүн	29	2,189,928.6	10	1,603,907.0	19	586,021.6	29	2,189,928.6	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БХД-ийн ИТХ	1	20,000.0					1	20,000.0				
БХД-ийн ЗДТГ	5	9,579.5					5	9,579.5				
БХД-ийн ДАА												
БХД-ийн ХАА												
БХД-ийн ЖДҮДТ	1	415.3					1	415.3				
БХД-ийн Соёлын ордон												

Нийслэлийн Багахангай дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БХД-ийн Хөрөнгө оруулалт	1	32,781.0					1	32,781.0			
БХД-ийн ОНХС											
Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ	2	38,873.7					2	38,873.7			
Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ	2	1,300.4					2	1,300.4			
Багахангай Тохижилт ОНӨААТҮГ	2	1,405.0	1	1,405.0			1	-			
Байгаль хамгаалах сан											
Дүн	14	104,354.9	1	1,405.0	0	-	13	102,949.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
БХД-ийн ИТХ	3	36,581.3					3	36,581.3
БХД-ийн ЗДТГ	2	6,450.0			1	6,450.0	1	-
БХД-ийн ДАА	1	5,662.5			1	5,662.5		
БХД-ийн ХАА								
БХД-ийн ЖДҮДТ								
БХД-ийн Соёлын ордон	1	25,551.4					1	25,551.4
БХД-ийн Хөрөнгө оруулалт								
БХД-ийн ОНХС								
Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ								
Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ	3	326,965.7			1	302,970.3	2	23,995.4
Багахангай Тохижилт ОНӨААТҮГ								
Дүн	10	401,210.9	-	-	3	315,082.8	7	86,128.1